



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/104

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн О.Мөнхбаяр (АЮ66061817)-ын Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 1 дүгээр гудамж 130 тоотод байршилтай 6308002484 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 1146 м2 газар, П.Батням (ГЮ88041305)-ын Булган сум 5 дугаар баг Агуулахын товог 2 дугаар гудамж 200г тоотод байршилтай 6308002478 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 38 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр сунгасугай.

2. О.Мөнхбаяр, П.Батням нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

